

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/227-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2023 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14-15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15-16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-17
4. Аудитын тайлан	18-120
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18-19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УЦУОШТ	Ус цаг уур орчны шинжилгээний төв
ЦУОШГ	Цаг уур орчны шинжилгээний газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-25 № ЦАА-2023/227-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.ЭНХСЭЛЭНГЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.7 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 0.3 хувиар хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 0.3 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 92.6 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 48,623.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмжид 19,587.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>87,490,826.10</u>	<u>80,300,940.35</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	87,490,826.10	80,300,940.35
351	Түүхий эд материал	52,903,173.52	47,235,357.77
35110	Тусгай зориулалттай материал	52,903,173.52	47,235,357.77
354	Хангамжийн материал	34,587,652.58	33,065,582.58
35410	Бичиг хэргийн материал	1,306,100.00	1,295,700.00
35420	Аж ахуйн материал	7,383,922.58	5,592,352.58
35430	Сэлбэг хэрэгсэл	18,789,080.00	19,367,480.00
35440	Түлш, шатах тослох материал	3,085,000.00	2,750,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,023,550.00	4,060,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>827,614,674.95</u>	<u>790,755,158.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	827,614,674.95	790,755,158.98
392	Биет хөрөнгө	566,831,674.95	530,027,158.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	343,282,534.09	363,282,534.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,662,807.41	-63,364,658.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,767,573.78	104,767,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,588,703.09	-44,716,632.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,419,328.09	275,665,346.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,849,198.81	-110,015,394.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,281,560.00	15,281,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,818,611.70	-10,873,170.46
393	Биет бус хөрөнгө	260,783,000.00	260,728,000.04
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-54,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	260,508,000.00	260,508,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>915,105,501.05</u>	<u>871,056,099.33</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>915,105,501.05</u>	<u>871,056,099.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	915,105,501.05	871,056,099.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,295,182,634.93	1,295,182,634.93
51101	Өмч: - төрийн	1,295,182,634.93	1,295,182,634.93
512	Хуримтлагдсан үр дүн	-504,917,482.55	-548,966,884.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-504,917,482.55	-504,917,482.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-44,049,401.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,840,348.67	124,840,348.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>915,105,501.05</u>	<u>871,056,099.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



 /Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,459,943,852.85	1,356,676,162.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	274,482,836.85	92,637,249.11
120	Нийтлэг татварын бус орлого	274,482,836.85	92,637,249.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,130,000.00	1,255,601.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,130,000.00	1,255,601.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,185,461,016.00	1,264,038,913.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,122,011,400.00	1,204,183,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,122,011,400.00	1,204,183,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,449,616.00	59,855,113.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,710,616.00	20,272,013.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,739,000.00	9,583,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,271,931,217.42	1,400,725,563.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,271,931,217.42	1,400,725,563.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,268,176,602.60	1,377,200,743.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	936,632,886.50	998,805,869.60
210101	Үндсэн цалин	688,596,575.00	717,134,763.80
210102	Нэмэгдэл	220,662,379.50	215,690,125.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,373,932.00	57,298,997.80
210104	Урамшуулал	00.00	8,681,983.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,865,049.00	126,170,047.00
210201	Тэтгэврийн даатгал	87,878,262.00	86,492,447.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,227,500.00	9,919,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,380,433.00	7,935,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,655,406.00	1,983,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,723,448.00	19,838,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,107,763.24	67,724,046.00
210301	Гэрэл, цахилгаан	10,275,233.24	9,337,514.00
210302	Түлш, халаалт	40,149,979.00	55,142,032.00
210303	Цэвэр, бохир ус	2,682,551.00	3,244,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,061,858.08	26,655,597.00
210401	Бичиг хэрэг	1,246,450.00	1,077,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,118,430.00	15,710,782.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,164,000.00	2,132,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,800.00	125,800.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,761,823.85	3,371,095.00
210408	Бараа материал акталсны зардал	1,763,354.23	4,238,120.00
2105	Нормативт зардал	1,107,390.00	1,693,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	761,090.00	1,613,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,300.00	80,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,137,736.50	32,571,587.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	63,970,236.50	27,711,157.75
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	385,000.00	
210604	Урсгал засвар	5,782,500.00	4,860,430.00
2107	Томилолт, зочны зардал	4,649,465.00	4,033,200.00
210702	Дотоод албан томилолт	4,649,465.00	4,033,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,941,883.44	8,441,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,529,543.44	7,211,900.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	334,600.00	
210803	Даатгалын үйлчилгээ	236,125.00	316,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,515.00	320,015.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	140,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	249,800.00
210807	Газрын төлбөр	255,100.00	202,317.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,672,570.84	111,105,533.97
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,672,570.84	111,105,533.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,754,614.82	23,524,820.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	19,587,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	19,587,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,754,614.82	3,723,244.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,754,614.82	3,723,244.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	214,576.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	214,576.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>188,012,635.43</u>	<u>-44,049,401.72</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>188,012,635.43</u>	<u>-44,049,401.72</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,186,591,016.00	1,265,294,514.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,130,000.00	1,255,601.11
120	Нийтлэг татварын бус орлого	1,130,000.00	1,255,601.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,130,000.00	1,255,601.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,130,000.00	1,255,601.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,185,461,016.00	1,264,038,913.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,122,011,400.00	1,204,183,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,122,011,400.00	1,204,183,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,449,616.00	59,855,113.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,710,616.00	20,272,013.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,739,000.00	9,583,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,159,591,065.00	1,258,836,707.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,159,591,065.00	1,258,836,707.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,836,450.18	1,235,311,886.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	936,632,886.50	998,805,869.60
210101	Үндсэн цалин	671,038,934.00	717,134,763.80
210102	Нэмэгдэл	238,189,102.50	215,690,125.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,404,850.00	57,298,997.80
210104	Урамшуулал	00.00	8,681,983.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,865,049.00	126,170,047.00
210201	Тэтгэврийн даатгал	87,878,262.00	86,492,447.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,227,500.00	9,919,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,380,433.00	7,935,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,655,406.00	1,983,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,723,448.00	19,838,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,680,263.24	67,389,046.00
210301	Гэрэл, цахилгаан	10,275,233.24	9,337,514.00
210302	Түлш, халаалт	38,722,479.00	54,807,032.00
210303	Цэвэр, бохир ус	2,682,551.00	3,244,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,742,113.00	21,697,282.00
210401	Бичиг хэрэг	1,160,950.00	1,377,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,118,430.00	15,710,782.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,164,000.00	2,132,500.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,800.00	125,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,290,933.00	2,350,800.00
2105	Нормативт зардал	1,107,290.00	1,798,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	761,090.00	1,613,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,200.00	185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,217,500.00	6,976,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,687,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	435,000.00	429,000.00
210604	Урсгал засвар	5,782,500.00	4,860,430.00
2107	Томилолт, зочны зардал	4,649,465.00	4,033,200.00
210702	Дотоод албан томилолт	4,649,465.00	4,033,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,941,883.44	8,441,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,529,543.44	7,211,900.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	334,600.00	
210803	Даатгалын үйлчилгээ	236,125.00	316,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,515.00	320,015.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	140,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	249,800.00
210807	Газрын төлбөр	255,100.00	202,317.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,754,614.82	23,524,820.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	19,587,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	19,587,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,754,614.82	3,723,244.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,754,614.82	3,723,244.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	214,576.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	214,576.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>26,999,951.00</u>	<u>6,457,807.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,999,951.00	6,457,807.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,999,951.00	6,457,807.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,999,951.00	6,457,807.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,999,951.00	6,457,807.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-26,999,951.00</u>	<u>-6,457,807.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн 4317143998
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,674,634.93	49,147,200.59	-555,840,532.40	527,981,303.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,428,208.30	2,428,208.30
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,674,634.93	49,147,200.59	-553,412,324.10	530,409,511.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-2,428,208.30	00.00	-2,428,208.30
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-137,893,671.17	-137,893,671.17
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	-504,917,482.55	915,105,501.05
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	-504,917,482.55	915,105,501.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	-504,917,482.55	915,105,501.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-44,049,401.72	-44,049,401.72
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,295,182,634.93	124,840,348.67	-548,966,884.27	871,056,099.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,205,183,800.00	1,201,716,156.60	3,467,643.40	99.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,205,183,800.00	1,201,716,156.60	3,467,643.40	99.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,185,596,800.00	1,182,129,156.60	3,467,643.40	99.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	990,941,100.00	987,701,463.60	3,239,636.40	99.67
210101	Үндсэн цалин	707,605,100.00	706,030,357.80	1,574,742.20	99.78
210102	Нэмэгдэл	217,193,200.00	215,690,125.00	1,503,075.00	99.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,442,800.00	57,298,997.80	143,802.20	99.75
210104	Урамшуулал	8,700,000.00	8,681,983.00	18,017.00	99.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,992,600.00	124,812,511.00	180,089.00	99.86
210201	Тэтгэврийн даатгал	85,315,000.00	85,134,911.00	180,089.00	99.79
210202	Тэтгэмжийн даатгал	9,919,400.00	9,919,400.00	00.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,935,500.00	7,935,500.00	00.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,983,900.00	1,983,900.00	00.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,838,800.00	19,838,800.00	00.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,623,600.00	48,623,600.00	00.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,193,500.00	9,193,500.00	00.00	100.00
210302	Түлш, халаалт	36,185,600.00	36,185,600.00	00.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,244,500.00	3,244,500.00	00.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,025,800.00	8,025,800.00	00.00	100.00
210401	Бичиг хэрэг	657,400.00	657,400.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,559,300.00	4,559,300.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,632,500.00	1,632,500.00	00.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	125,800.00	125,800.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,050,800.00	1,050,800.00	00.00	100.00
2105	Нормативт зардал	185,000.00	185,000.00	00.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	185,000.00	185,000.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,209,700.00	3,209,650.00	50.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,687,200.00	1,687,150.00	50.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	429,000.00	429,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	1,093,500.00	1,093,500.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,449,100.00	1,449,100.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,449,100.00	1,449,100.00	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,169,900.00	8,122,032.00	47,868.00	99.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,892,600.00	6,892,600.00	00.00	100.00

210803	Даатгалын үйлчилгээ	316,500.00	316,500.00	00.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,100.00	320,015.00	85.00	99.97
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,800.00	140,800.00	00.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	249,800.00	249,800.00	00.00	100.00
210807	Газрын төлбөр	250,100.00	202,317.00	47,783.00	80.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19587000.00	19587000.00	00.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,587,000.00	19,587,000.00	00.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,587,000.00	19,587,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,205,183,800.00	1,201,971,757.30	3,212,042.70	99.73
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,204,183,800.00	1,200,716,156.19	3,467,643.81	99.71
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,204,183,800.00	1,200,716,156.19	3,467,643.81	99.71
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,255,601.11	-255,601.11	125.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,255,601.11	-255,601.11	125.56
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	80	77	03	96.25
620001	Удирдах ажилтан	01	01	00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	76	73	03	96.05
620003	Үйлчлэх ажилтан	03	03	00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,640,537.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,069,730.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,069,730.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,104,406.00
210101	Үндсэн цалин	11,104,406.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,357,536.00
210201	Тэтгэврийн даатгал	1,357,536.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,765,446.00
210301	Гэрэл, цахилгаан	144,014.00
210302	Түлш, халаалт	18,621,432.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,671,482.00
210401	Бичиг хэрэг	720,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,151,482.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00
2105	Нормативт зардал	1,613,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,613,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,653,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,887,000.00
210604	Урсгал засвар	3,766,930.00
2107	Томилолт, зочны зардал	2,584,100.00
210702	Дотоод албан томилолт	2,584,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	319,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	319,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	570,807.00
2200	Дотоод эх үүсвэрээр	570,807.00
221001	Их засвар	570,807.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,855,113.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,855,113.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,272,013.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,583,100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь /цаашид Ус цаг уур, орчны шинжилгээний төв гэх/ “Үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах, байгаль цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргэмжлүүлэх, цаг агаар уур амьсгалын нөөцийг бүрэн дүүрэн ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Ус цаг уур орчны төлөв байдлын урьдчилсан болон горимын үнэн зөв мэдээ, мэдээллээр төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд шуурхай үйлчлэх
- Нутаг дэвсгэртээ нислэг үйлдэж буй агаарын хөлгийн нислэгт цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээгээр үйлчилж нислэгийн аюулгүй байдлыг хангах
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний өртөө харуулуудыг арга зүйн удирдлагаар хангаж, тэдгээрийн тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, холбоо, мэдээлэл сүлжээний найдвартай ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах
- Шинжилгээний зориулалттай хэмжих хэрэгслийн хангалт, техник технологийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх, багаж төхөөрөмж материалын нэгдсэн судалгаа гаргах, ашиглалтад хяналт тавих
- Шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлын чиглэлээр гарч буй дүрэм заавар, стандартыг мөрдөж хэрэгжүүлэх
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах
- Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах, ажилд нь сургаж дадлагажуулах мэргэжлийг дээшлүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд БОАЖЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦУОШГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/170 дугаар тушаалаар Цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,049.4 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-

Авлага	-	-	-
Бараа материал	87,490.80	80,300.90	-7,189.9
Үндсэн хөрөнгө	827,614.70	790,755.20	-36,859.5
Нийт хөрөнгө	915,105.50	871,056.10	-44,049.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	915,105.50	871,056.10	-44,049.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	915,105.50	871,056.10	-44,049.40

Бараа материалын дансны үлдэгдэл 80,300.9 мянган төгрөг болж 7,189.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 34,064.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ЦУОШГ-аас 23,593.4 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан болон 4,238.1 мянган төгрөгийн бараа материал акталж, 60,609.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,019,780.0 мянган төгрөг болж 74,246.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,457.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 67,788.2 мянган төгрөгийн их засварын ажил болон автомат станцыг болон ЦУОШГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 871,056.1 мянган төгрөг болж 44,049.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,323,734.0 мянган төгрөг, өөрийн орлогоос 1,000.0 мянган төгрөг буюу нийт 1,324,734.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 187,573.6 мянган төгрөгөөр бууруулж / байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 48,784.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 39,226.0 мянган төгрөгөөр хангамж, бараа материалын зардлыг 27,362.6 мянган төгрөгөөр, цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 16,769.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 13,105.5 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./ 1,137,160.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 68,023.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,310.0 мянган төгрөгөөр,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 2,462.3 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 1,373.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж,
- Цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 77,840.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.



Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,205,183.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс 1,204,183.8 мянган төгрөг, өөрийн орлогоос 1,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,204,183.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,255.6 мянган төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,201,460.6 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 3,467.6 мянган төгрөгөөр хэмнэж, 255.6 мянган төгрөгийн өөрийн орлогыг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,179,548.40	1,175,825.20	3,723.20	99.7
2	Холбооны суваг ашигласны хөлс	6,048.40	6,048.40	0.00	100.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	19,587.00	19,587.00	0.00	100.0
	Дүн	1,205,183.80	1,201,460.60	3,723.20	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130013404 тоот дансанд ЦУОШГ-аас 20,272.0 мянган төгрөг, Сангийн сайдын 2022 оны 243 дугаар тушаалаар үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгосон 9,583.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын ерөнхий данснаас цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас, нэмэгдүүлэх ажлын 30,000.0 мянган төгрөг зэрэг нийт 59,855.1 мянган төгрөг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөгдлөө.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,271,931.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,719.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт


Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЦУОШГ-ын даргын 2022 оны А-1/585 дугаар “Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээний тухай” албан бичгийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,



нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Ус цаг уур орчны шинжилгээний төвийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Ус цаг уур орчны шинжилгээний төв нь төрийн албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын зардлыг тухайн оны төсөвт тусгаж батлуулаагүйгээс албан хаагчдын улирлын ажлын мөнгөн урамшууллыг улирал бүр олгоогүй байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.3-д “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан хаагчдын улирлын ажлын мөнгөн урамшууллын зардлыг төсөвт тусган батлуулж, олгож байх зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар автомашины засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэхийг тогтоож, хэлэлцэж шийдвэрлээгүй, худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй болон ур чадварын нэмэгдлийг улирал бүр дүгнээгүй зэрэг 3 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	22,740.6	3	22,740.6	100
Нийт дүн	3	22,740.6	3	22,740.6	100



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:


4.6.1 Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн 2022 оны төсвийг бодит хэрэгцээ шаардлага, төсвийн төсөлд өгсөн саналыг үндэслэлгүйгээр багасгаж баталсан байна. Үүнээс шалтгаалан жилийн эцэст буюу ЦУОШГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/238 дугаар тушаалаар үндсэн үйл ажиллагааны дутагдсан санхүүжилт болох **19,701.2** мянган төгрөгийг / тогтмол зардал 18,765.4 мянган төгрөг, бусад зардал 935.8 мянган төгрөг / үндсэн үйл ажиллагааны зардлын дансанд бус нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн ... **үнэн зөв** байдлыг хангасан байх”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь “**Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг** хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтууд болон тус хуулийн **47 дугаар зүйлийг** зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Үр дүнгийн урамшууллын зардлыг төсөвт тусган батлуулж, олгоогүй	1							1
Дүн	1							1
Нийт дүн	1							1